



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК

2024.04.26

## АГУУЛГА

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал:

### Танилцах асуудал

- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга

### Хэлэлцэх асуудал

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах;
  - Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай;
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл
  8. Саналын хуудасны загвар

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 03 сарын 15-ны өдрийн 11 дүгээр  
тогтоолын Хоёрдугаар хавсралт

## "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 11 дугаар тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

**Компанийн оноосон нэр:** "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3

**Хурал болох газар:** "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудас

**Хурал болох өдөр, цаг:** 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 09:00 цагт

**Хурал болох хэлбэр:** цахим (зайнаас)

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:** 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

**Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:**

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр;
3. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан;
4. Компанийн 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан;
5. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
6. Компанийн 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний санал;
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл;
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл.

Хувьцаа эзэмшигч Та 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09:00 - 17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл ([www.mse.mn](http://www.mse.mn)) цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн байр Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3
- Хурал зохион байгуулах комиссын утас: 11-313747, цахим шуудан ([shareholders@mse.mn](mailto:shareholders@mse.mn))

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3 "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн байранд ирж, эсхүл цахим хэлбэрээр "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн цахим хуудас ([www.mse.mn](http://www.mse.mn))-аар өгөх ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 15:00 цаг байна.

~o0o~



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал  
хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.4, 4.5 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 7.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 09:00 цагт цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д даалгасугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр олон нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2024 оны 4 дүгээр сарын 04-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.

1524010027


6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралт, хурлын зарын загварыг Хоёрдугаар хавсралт, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг Гуравдугаар хавсралт, саналын хуудасны загварыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг Тавдугаар хавсралт, хурлын тооллогын комиссыг Долдугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай цахим шийдэлд тавигдах шаардлагыг Долдугаар хавсралтаар баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой программ хангамжийн бэлтгэл ажлыг хангахыг гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай танилцах боломжийг хувьцаа эзэмшигч бүрд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 15:00 цаг хүртэл хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаягт байрлах "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн байранд цаасан болон цахим хэлбэрээр (www.mse.mn) урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Ж.Цогтбаяр)-т даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комисс (Б.Онон)-т даалгасугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-ыг томилсугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад шаардлагатай материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 03 сарын 15-ны өдрийн 77 дугаар  
тогтоолын Зуравдугаар хавсралт



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИСС**

Комиссын дарга: "БиДиСек ҮЦК" ХК-ийн Харилцагчийн албаны захирал  
Б.Онон

Комиссын гишүүд: Мэргэжилтэн М.Мишээл, Г.Энхжин

Комиссын нарийн  
бичгийн дарга: Дотоод аудитор О.Ангирмаа, Г.Байгал

~000~

## "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

ХУГАЦАА	ХӨТӨЛБӨР	ХАРИУЦАГЧ
08:30-09:00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Хурал зохион байгуулах комисс
09:00-09:05	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комисс
09:05-09:10	Хурлын үйл ажиллагааг нээж үг хэлэх	Хурлын дарга
09:10-09:15	Хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга
09:15-09:25	Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр хэрхэн санал өгөх талаарх видео зааврыг танилцуулах	Тооллогын комисс
09:25-09:45	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч ТУЗ-ийн дарга Хяналтын зөвлөлийн дарга
09:45-09:55	Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах	ТУЗ-ийн дарга
09:55-10:15	Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай	ТУЗ-ийн дарга
10:15-10:35	Асуулт, хариулт	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
10:35-11:00	Санал хураалт, санал тоолох	Тооллогын комисс
11:00-11:10	Санал хураалтын дүнг нэгтгэн, танилцуулах	Тооллогын комисс
11:10-11:15	Хурлаас гаргасан шийдвэрийг танилцуулж, хурлыг хааж үг хэлэх	Хурлын дарга



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

### "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН 2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн (цаашид "МХБ" гэх) Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-ийн холбогдох журам, заавар, компанийн дүрэм болон энэхүү дэгийг баримтлан зохион байгуулна.
- 1.2 Хуралд оролцогч нь хувьцаа эзэмшигчдийн хурал дуссанаас хойш ажлын 5 хоногийн дотор саналаа төлөөлөн удирдах зөвлөлд гаргана.
- 1.3 Энэ дэгийн 1.2-т заасан саналыг судлан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах эсэх асуудлыг төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

#### Хоёр. Хурлын дарга, түүний эрх, үүрэг

- 2.1. Хурлын дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр эсхүл хурлын даргыг томилсон шийдвэрт заасан этгээд байна.
- 2.2. Хурлын дарга дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
  - 2.2.1. Хурлыг нээж, хуралд оролцогчдод дэгийг танилцуулах;
  - 2.2.2. Хуралд оролцогчдод асуулт асуух зөвшөөрөл олгох;
  - 2.2.3. Хурлыг дэгийн дагуу удирдан явуулж, хуралд оролцогчдоос дэгийг сахин биелүүлэхийг шаардах.Хуралдааны дэг зөрчсөн этгээдэд энэхүү дэгийн 7-д заасан хариуцлага тооцох эрхтэй;
  - 2.2.4. Хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг мэдээлж, эцсийн шийдвэрийг сонсгох.

#### Гурав. Хуралд оролцох

- 3.1. Хуралд оролцогч нь хурал эхлэхээс 30 минутын өмнө хуралд оролцох бэлтгэлээ хангаж, бүртгэлээ баталгаажуулсан байна.
- 3.2. Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч иргэн нь цахимаар хуралд оролцохдоо өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэх, итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг цахим системд бүртгүүлнэ. Энэхүү итгэмжлэл нь зөвхөн тухайн хуралдаа хүчинтэй болно.
- 3.3. Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь цахим хэлбэрээр хуралд оролцохдоо өөрийн компанийн хүчин төгөлдөр гэрчилгээ /эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хувилбар/-г системд оруулна. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг гэрчилгээний хамт системд оруулна.
- 3.4. Хуралд оролцогчийг дараах тохиолдолд хуралд оролцуулахгүй, хурлын системээс хасна. Үүнд:

- 3.4.1. хувьцаа эзэмшигч биш байх;
- 3.4.2. хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох эрхтэйг гэрчлэх бичиг баримт бүртгүүлээгүй байх;
- 3.4.3. хүчин төгөлдөр бичиг баримтын шаардлага хангаагүй байх;
- 3.4.4. цахим хурлын үеэр эмх, замбараагүй байдал бий болгох;
- 3.4.5. хурлын даргын сануулгыг удаа дараа зөрчих;
- 3.4.6. ёс бус үг хэллэг хэрэглэх.

### **Дөрөв. Асуулт, хариулт**

- 4.1. Хуралд оролцогчдын асуулт, хариулт нь хэлэлцэх асуудалтай шууд холбоотой товч, тодорхой байна.
- 4.2. Хурлын дарга нь хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хуралд оролцогчдоос асуулт байгаа эсэхийг асууна.
- 4.3. Асуулт асуух оролцогч нь цахим талбар дахь **RAISE HAND** тэмдэглэгээг дарж мэдэгдэнэ.
- 4.4. Хурал зохион байгуулагч нь асуулт асуух хувьцаа эзэмшигчдийг цаг, хугацааны дарааллын дагуу овог, нэр, асуултыг хурлын даргад танилцуулна.
- 4.5. Асуултад компанийн эрх бүхий албан тушаалтан хариулна.
- 4.6. Асуултад хариулах этгээд нь хэлэлцэх асуудалтай холбоогүй асуултад хариулахаас татгалзах эрхтэй.
- 4.7. Асуултыг хурлын системээр дамжуулан коммент, чат хэлбэрээр асууна.
- 4.8. Хуралд оролцогчийн асуултад хариулах хугацаа хоёр минутаас илүүгүй байна.
- 4.9. Тодорхой асуудлаар шаардлагатай гэж үзвэл асуултад хариулах хугацааг дарга өөрчлөн тогтоож болно.
- 4.10. Асуултад хариулж дууссаны дараа хурал зохион байгуулах комисс асуултуудыг цуглуулж ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

### **Тав. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал өгөх**

- 5.1. Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудалтай холбоотойгоор нэг санал өгөх эрхтэй.
- 5.2. Хуралд оролцогч хурлын өмнө санал өгөх цахим заавартай танилцсан байх бөгөөд тус зааврын дагуу саналаа өгөөгүй бол тухайн саналыг хүчингүйд тооцно.
- 5.3. Хэлэлцэх асуудлаар санал өгөхдөө [hural.mse.mn](http://hural.mse.mn) сайтын нэвтрэх хэсгийн НЭР гэх цонхонд өөрийн утасны дугаарыг, НУУЦ ҮГ гэх цонхонд утасны дугаарт ирсэн нууц үгийг оруулж нэвтэрнэ.
- 5.4. Нэвтэрсний дараа хурлаар хэлэлцэж буй асуудлын жагсаалтын Нэг, Хоёр дахь асуудлын харалдаа байрлах “ЗӨВШӨӨРСӨН”, “ТАТГАЛЗСАН”, “ТҮДГЭЛЗСЭН” хэсгээс сонгон саналаа тэмдэглэн оруулна.
- 5.5. Саналыг зөвхөн нэг удаа өгөх тул сайтар нягталж шалгасны дараа санал өгөх товчийг дарж саналаа илгээнэ.

### **Зургаа. Санал тоолох, саналыг нэгтгэн танилцуулах**

- 6.1. Саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд тусгагдсан тооллогын комисс цахим программ нэгтгэсэн тайланг тэмдэглэн авна.
- 6.2. Тооллогын комиссын дарга нь нэгтгэгдсэн саналыг хурлын даргад танилцуулна.
- 6.3. Нийт саналыг нэгтгэсэн цахим системийн тайлан /хүчин төгөлдөр болон хүчин төгөлдөр бус/-г хамтад нь ТУЗ-ийн НБД хүлээлгэн өгч, бусад хурлын материалын хамт компанийн архивт хадгалуулна.

### **Долоо. Хариуцлага**

- 7.1. Хуралд оролцогч хурлын үед дэг зөрчсөн, бусдыг доромжилсон бол хурал дарга дараах хариуцлагыг хүлээлгэнэ. Үүнд:
  - 7.1.1. дэг баримтлахыг нэр заан шаардах;
  - 7.1.2. сануулга өгөх;
  - 7.1.3. урьдчилан сануулга авсан хуралд оролцогчийг дахин зөрчил гаргавал түүнийг тухайн өдрийн хурлын системээс хасах;
- 7.2. Энэхүү дэг нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал дуусгавар болсноор хүчингүй болно.

~oOo~

# ТАНИЛЦАХ АСУУДАЛ

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

2023 он **7,453**

2022 2023

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



231,305,936  
Хувьцааны тоо ширхэг



119,157,603  
Хувьцааны тоо ширхэг

ЗАХ ЭЗЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	₮6.89 их наяд	₮11.6 их наяд
ТОП-20 ИНДЕКС	37,565.55 нэгж	41,437.42 нэгж
БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИЙН ТОО	183	173
ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖАА	₮2.4 тэрбум	₮33.3 тэрбум

## БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг. ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй. Компанийн дунд хугацааны төлөвлөлт буюу 2023-2027 оны стратегийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна. ТУЗ-ийн үүргийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн дүрэм болон "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам"-д тодорхой заасан байдаг.

### Аудитын хорооны бүрэлдэхүүн

Н. Улаанхүү	Хорооны дарга
Р. Мөнхтөр	Гишүүн
Ж. Цогтбаяр	Гишүүн

### Цалин, урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Р. Мөнхтөр	Хорооны дарга
Н. Улаанхүү	Гишүүн
С. Баянцогт	Гишүүн

### Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

Н. Отгончимэг	Хорооны дарга
М. Банзрагч	Гишүүн
Т. Ганбаатар	Гишүүн

### Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн

М. Банзрагч	Хорооны дарга
Н. Отгончимэг	Гишүүн
Ж. Бямбасүрэн	Гишүүн

## ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

"Компанийн тухай хууль"-ийн 75.9 дэх зүйлд заасны дагуу МХБ-ийн ТУЗ-ийн гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдаж, сургалтын гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагын дагуу 2023 онд шинээр томилогдсон ТУЗ-ийн бүх гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдан гэрчилгээг авсан байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. 2023 онд ТУЗ нийт 26 удаа хуралдсан. ТУЗ-ийн хурлаар нийт 60 гаруй асуудал хэлэлцэн, компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн дотоод ажилтай холбоотой 53 тогтоол гаргаж, 6 тэмдэглэлээр гүйцэтгэх удирдлагад үүрэг, даалгавар өгч ажилласан.

ТУЗ-ийн 26 удаагийн хурал Улаанбаатар хотод Сангийн яам болон МХБ-ийн хурлын танхимд зохион байгуулагдсан ба 3 удаагийн хурал цахим хэлбэрээр явагдсан байна.

## Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг хариуцлагын талаар Компанийн дүрэмд тодорхой заасан байдаг. Гүйцэтгэх захирал нь МХБ-ийн өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг хариуцаж, ТУЗ-өөс баталсан үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй. ТУЗ-ийн 2017 оны 10 сарын 02-ны өдөр байгуулсан "Хөлсөөр ажиллах гэрээ"-г сунгахаар шийдвэрлэсний дагуу тайлант хугацаанд гүйцэтгэх захирлаар Х.Алтай ажилласан. 2023 онд МХБ-ийн 2023 оны бизнес төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, холбогдох дүрэм журмыг боловсруулж ажилласан.

## Гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх

Гүйцэтгэх захирал Х.Алтай ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд МХБ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг жил тутам үнэлэн дүгнэлт гаргадаг. Төрийн өмчийн хорооноос баталсан "Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг тэнцвэржүүлсэн үнэлгээний аргаар дүгнэх, урамшуулал олгох журам"-ын дагуу Гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэхдээ үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл, эрсдэлийг удирдсан байдал, санхүүгийн зорилго, зорилтын биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт зэргийг төлөвлөлттэй харьцуулдаг. 2023 онд санхүүгийн зорилго, зорилтод хамаарагдах үзүүлэлт 100% гүйцэтгэлтэй байсан бол үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 80% байв.

## ХҮНИЙ НӨӨЦ

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг орчин үеийн хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, байгууллагын ажилтнуудын зан төлөвт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аливаа байгууллагын үндсэн үүргийн хувиар ажилтнуудын боловсрол, мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт зохион байгуулж, мөн нэмэлт ур чадварыг бий болгох чиглэлийг дэмжин ажиллав.

Хүний нөөцийн хөдөлгөөн, хуваарилалтыг амжилттай хэрэгжүүлснээр 2023 оны эцэст нийт 70 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.



70

Нийт ажилтан



22

Нийт эрэгтэй ажилтан



48

Нийт эмэгтэй ажилтан



38

Үндсэн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн



18

Дэмжих үйл ажиллагааны мэргэжилтнүүд



36

Дундаж нас



6 жил


Ажилласан дундаж хугацаа







16

Удаагийн сургалт

## 2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



## 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/54/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamj@audit.gov.mn  
Ахлах аудитор: Э.Энхбаатар  
Утас: 261628 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит ХХК  
-ийн захирал: С.Тунгалаг  
Утас: 70001778

Улаанбаатар хот  
2024 он





## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/781

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЦОГТБАЯР  
ТАНАА

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн татан төвлөрүүлсэн хөрөнгөөс урсгал зардалд зарцуулсан, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг хэтрүүлсэн зэрэг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 461.7 сая төгрөгөөр давсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйлийн 11.8, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.11-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын "төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоолоор Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох шийдвэр гаргасан байна.

Z:\Yawsan\_Bichgi\2024\0315 SNAG-66 Docx

0001951657

Санхүүгийн зохицуулах хорооны "Нэмж гаргаж буй үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай" 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 690 дугаар тогтоолоор нийтэд санал болгон нэмж гаргаж буй нэг бүр нь 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 119,157,603 /Нэг зуун арван есөн сая нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурав/ ширхэг хувьцааг бүртгэн тус компанийн нийт хувьцааг 350,463,539 (гурван зуун тавин сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун гучин есөн) ширхэг байхаар зөвшөөрлийг олгожээ.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь анхдагч арилжааг 2022 оны 12 дугаар сарын 26-наас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд анхдагч арилжааг амжилттай зохион байгуулж, Хоёрдогч арилжааг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр эхлүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 дүгээр тогтоолоор нэг бүр нь 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 350,463,539 ширхэг энгийн хувьцаатай буюу 11,915.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 35,046.4 сая төгрөгөөр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг компанийн дүрмээр баталсан байна.

Монголын хөрөнгийн бирж ХК- ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 2022 оны цэвэр ашиг болох 646.2 сая төгрөгөөс ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Монголын хөрөнгийн бирж ХК нь 2022 оны өөрийн хөрөнгийн дүнгийн 3 хувиар буюу 635.8 сая төгрөгийн уул уурхайн биржийн эрсдэлийн санг анх удаа байгуулж, Голомт банканд байршуулсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар тогтоолоор компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг 91.0 хувийн хэрэгжилттэй, "Хангалттай", 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Санхүүгийн үйл ажиллагааг "Сайжруулах шаардлагатай" гэж дүгнэсэн байна.

Компани нь 2023 онд 3 үндсэн зорилгын хүрээнд 14 зорилтыг хэрэгжүүлэхээр 33 багц ажил,117 арга хэмжээг төлөвлөсөн ба үйл ажиллагааны тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт аудитын явцад гараагүй байна.

Монгол Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналт удирдлагын газраас Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан 3 үндсэн зорилгын хүрээнд 14 зорилтыг хэрэгжүүлэхээр 33 багц ажил,117 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 80.3 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн нь өмнөх оны хяналт шинжилгээ үнэлгээний гүйцэтгэлийн үнэлгээнээс 7.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тус хяналт шинжилгээ үнэлгээгээр 12 зөвлөмж хүргүүлсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН** (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2022	12/31/2023
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,731,709,823.19	902,582,814,516.91
1.1.2	Дансны авлага	504,659,308.87	1,868,454,950.77
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	822,948.07	1,457,509.01
1.1.4	Бусад авлага	-	149,471,451.41
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	33,650,495.17	36,053,729.65
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,775,744.35	204,642,999.30
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	13,160,000.00	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10		-	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,296,778,319.65</b>	<b>904,842,895,157.05</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,536,483,495.31	5,453,061,929.98
1.2.2	Биет бус хөрөнгө	17,648,438,922.95	16,998,953,543.12
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9		-	-
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>23,184,922,418.26</b>	<b>22,452,015,473.10</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>25,481,700,737.91</b>	<b>927,294,910,630.15</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	793,176,221.30	265,821,383.36
2.1.1.2	Цалингийн өглөг	-	612,117.37
2.1.1.3	Татварын өглөг	-	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Эздийн өмчийн дүн	-	-
2.1.1.6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН** (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2022	12/31/2023
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	15,396,128.32	17,955,656.95
2.1.1.9	Нөөц / өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	149,471,451.41
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12	УУБ-ны арилжааны дэнчинд байршиж буй мөнгө	-	880,962,845,181.82
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>998,657,547.97</b>	<b>881,588,538,249.72</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	635,862,600.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	<b>990,846,139.66</b>	<b>990,698,992.92</b>
2.1.2.4	<b>Бусад урт хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>990,846,139.66</b>	<b>1,626,561,592.92</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,989,503,687.63</b>	<b>883,215,099,842.64</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>35,046,353,900.00</b>
	Өмч:		
2.3.1	а) төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.2	б) хувийн	-	-
2.3.3	в) хувьцаат	-	11,915,760,300.00
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,021,146,332.29	20,021,146,332.29
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(20,105,864,784.03)	(11,434,011,346.80)
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>23,492,197,050.28</b>	<b>44,079,810,787.51</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>25,481,700,737.91</b>	<b>927,294,910,630.15</b>

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН** (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2022	12/31/2023
<b>1</b>	<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>4,241,344,850.62</b>	<b>12,147,031,303.89</b>
1.1	Брокер, диллерийн үйл ажиллагааны орлого	4,241,344,850.62	-
1.2	Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	-	-
1.3	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	-	12,147,031,303.89
1.4	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого	-	-
<b>2</b>	<b>Түрээсийн орлого</b>		
<b>3</b>	<b>Хүүний орлого</b>	-	4,562,440,335
<b>4</b>	<b>Ногдол ашгийн орлого</b>	-	-
4.1	Хувьцааны ногдол ашиг		
4.2	Хараат болон хамтарсан компаниас олсон ашиг		
<b>5</b>	<b>Эрхийн шимтгэлийн орлого</b>	-	-
<b>6</b>	<b>Бусад орлого</b>	27,070,762.46	13,170,675.00
7	Борлуулалт маркетингийн зардал	-	186,062,107.06
<b>8</b>	<b>Ерөнхий ба удирдлагын зардал</b>	3,557,629,057.47	5,992,598,429.63
9	Санхүүгийн зардал	-	-
<b>10</b>	<b>Бусад зардал</b>	71,765,222.02	19,748,469.36
<b>11</b>	<b>Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/</b>	130,867,477.80	(186,717,492.52)
<b>12</b>	<b>Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/</b>	(141,003.17)	-
<b>13</b>	<b>Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/</b>	-	-
<b>14</b>	<b>Бусад ашиг /алдагдал/</b>	-	-
<b>15</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>769,747,808.22</b>	<b>10,337,515,816.10</b>
<b>16</b>	<b>Орлогын татварын зардал</b>	123,519,584.56	1,029,799,778.87
<b>17</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>646,228,223.66</b>	<b>9,307,716,037.23</b>
<b>18</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/</b>	-	-
<b>19</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>646,228,223.66</b>	<b>9,307,716,037.23</b>
<b>20</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>20,008,784,115.62</b>	-
20.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	20,008,784,115.62	-
20.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
20.3	Бусад олз /гарз/	-	-
<b>21</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>20,655,012,339.28</b>	<b>9,307,716,037.23</b>
<b>22</b>	<b>Татварын өглөг</b>	-	-

## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН 2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН БОЛОН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТУХАЙ

(2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд Төлөөлөн удирдах зөвлөлийн /2023.08.31/ №27 дугаар тогтоолоор баталсан Орлого зардлын төлөвлөгөөний тодотголоор нийт үйл ажиллагааны **9,783.7 сая** төгрөгийн орлого олж, үйл ажиллагааны **6,698.0 сая** төгрөгийн зардалтай ажиллан, компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд **3,032.8 сая** төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар төлөвлөсөн.

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2023 онд үйл ажиллагаанаас нийт **16,722.6 сая** төгрөгийн орлого олж, **6,198.4 сая** төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, нийт **10,524.2 сая** төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллаа. Санхүүгийн тайланд арилжааны МІТ цогц системийн 2023 оны элэгдэл хорогдолд 684.3 сая төгрөг, тухайн жилийн 1, 2, 3-р улирлын ашиглалт үйлчилгээний зардал болох 685.9 сая төгрөгийг төлж, 2023 оны 4 улирлын үйлчилгээний зардал болох 223.5 сая төгрөг түүнд ногдох 22.4 сая төгрөгийн нэмэгдсэн өртөгийн албан татварыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэв. Тайлант оны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд заасан төлөвлөгөөтэй харьцуулвал нийт үйл ажиллагааны орлого **170.9%-ийн**, үйл ажиллагааны зардал **92.5%-ийн** гүйцэтгэлтэй, татварын өмнөх цэвэр ашгийн төлөвлөгөөг **3.4 дахин** нэмэгдүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд биржээр үнэт цаасны **248** удаагийн арилжаа явагдаж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 172 ХК-ийн 1 тэрбум 136 сая ширхэг хувьцааг 518.4 тэрбум төгрөгөөр, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 747 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг 63.5 тэрбум төгрөгөөр, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 10 сая ширхэг нэгж эрхийг 6 тэрбум төгрөгөөр, компанийн өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.4 сая ширхэг бондыг 138 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт **726 тэрбум** төгрөгийн арилжаа хийсэн.

Нийт үнэт цаасны арилжааны шимтгэлээр **2.6 тэрбум** төгрөгийн орлого төвлөрүүлээ. Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 их наяд 731 тэрбум төгрөг буюу 1.7 дахин өсч, **11 их наяд 620 тэрбум** төгрөгт хүрсэн байна.

2023 онд биржээр уул уурхайн 299 удаагийн арилжаа амжилттай явагдаж 15,615,050 тонн уул уурхайн бүтээгдэхүүн арилжигдсан бөгөөд нүүрсний арилжаагаар 14,937,600 тонн нүүрс, төмрийн арилжаагаар 677,450 тонн төмрийн хүдэр болон баяжмал тус тус арилжигдсан байна. Компани уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны шимтгэлээр **6.8 тэрбум** төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллаа.

Компани 2023 онд Улсын төсөвт **2.2 тэрбум** төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлд **512.9 сая** төгрөгийг тус тус төлж ажилласан байна. (Дэлгэрэнгүйг Хүснэгт 1-д үзүүлэв.)

(Хүснэгт 1)

**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН 2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ХЭРЭГЖИЛТ**

/мянган төгрөг/

№	Үзүүлэлтүүд	2022 оны гүйцэтгэл*	2023 он		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
<b>1</b>	<b>Үйл ажиллагааны нийт орлого:</b>	<b>4,262,052</b>	<b>9,783,712</b>	<b>16,709,471</b>	<b>171%</b>
1.1	Үнэт цаасны арилжааны шимтгэл	2,031,112	4,112,424	2,598,470	63%
1.2	УУББ-ийн арилжааны шимтгэл		2,552,931	6,855,221	269%
1.3	Жилийн хураамж, үйлчилгээний хөлс	1,869,696	2,365,350	2,425,931	103%
1.4	Хүүгийн орлого		397,500	4,562,440	1148%
1.5	Бусад	361,244	355,507	267,409	75%
<b>2</b>	<b>Үйл ажиллагааны нийт зардал:</b>	<b>3,629,535</b>	<b>6,698,000</b>	<b>6,198,409</b>	<b>93%</b>
2.1	Үйл ажиллагааны зардал	2,011,822	3,997,527	3,885,530	97%
2.2	ҮХ элэгдлийн зардал	396,509	928,994	609,066	66%
2.3	Арилжааны систем ашиглалтын зардал	1,221,204	1,771,479	1,703,813	96%
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны татварын өмнөх ашиг/алдагдал</b>	<b>769,748</b>	<b>3,085,712</b>	<b>10,337,516</b>	<b>3.3 дахин</b>
4	Орлогын татвар	123,520	391,086	1,029,800	2.6 дахин
<b>5</b>	<b>Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>646,228</b>	<b>2,694,626</b>	<b>9,307,716</b>	<b>3.4 дахин</b>
6	Нийт авлага /цэвэр/	504,659	51,460	2,019,384	39 дахин
7	Нийт өглөг /системийн зардал оруулж тооцсоноор/	1,989,504	218,319	883,215,100	404 дахин
7.1	УУББ-ийн арилжааны дэнчингийн мөнгө			880,962,845	
7.2	Нөөц /өр төлбөр-эрсдэлийн сан/			635,863	
8	Ажиллагсдын тоо	53	72	70	<b>97%</b>
9	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	0.85	0.68	0.37	<b>54%</b>
10	Хөрөнгө оруулалт	557,807	5,899,400	1,028,728	

**Үйл ажиллагааны орлогын талаар:**

"Монголын хөрөнгийн бирж" ХК нь "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 ба 47.4-т заасны дагуу үнэт цаасны арилжаа эрхлэх үндсэн үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой хуулиар хориглоогүй бусад үйлчилгээг эрхлэн явуулж ирсэн.

Улсын Их Хурлаас 2022 онд "Уул уурхайн биржийн тухай" хуулийг баталж, компани Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдөр уул уурхайн биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсанаар уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжаагаар үйл ажиллагаа тэлж, дараах 13 төрлийн орлогыг олж, үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг болсон.

Үүнд компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд үйл ажиллагааны орлогыг 9,783.7 сая төгрөгт хүргэж ажиллахаар төлөвлөснөөс жилийн гүйцэтгэлээр **16,722.6** сая төгрөгийн орлогыг амжилттай төвлөрүүлж, жилийн үйл ажиллагааны нийт орлого **171%**-ийн гүйцэтгэлтэйгээр ажиллаа.

Дэлгэрэнгүйг (Хүснэгт 2) харна уу.



(Хүснэгт 2)

## ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

/мян.төг/

#	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 он		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
<b>A</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>4,268,417</b>	<b>9,783,712</b>	<b>16,722,642</b>	<b>170.9%</b>
1	Хувьцааны арилжааны шимтгэл	1,710,023	2,767,633	2,464,642	89%
2	Бондын арилжааны шимтгэл	293,483	1,270,395	91,084	7%
3	ХОС-ын нэгж эрх арилжааны шимтгэл	27,607	74,396	42,745	57%
4	Нүүрсний арилжааны шимтгэл		2,454,494	6,678,705	272%
5	Төмөр, жоншны арилжааны шимтгэл		98,437	176,517	179%
6	Гишүүнчлэлийн жилийн хураамж	69,139	76,590	109,282	143%
7	Терминал ашигласны хураамж	61,439	71,760	63,411	88%
8	Бүртгэх үйлчилгээний орлого	1,357,192	1,784,419	1,861,853	104%
9	Бүртгэлтэй компанийн жилийн хураамж	381,926	432,581	391,385	90%
10	Сургалтын орлого		40,000	8,182	20%
11	Мэдээллийн үйлчилгээний орлого	185,380	202,557	163,919	81%
12	Хүүгийн орлого		397,500	4,562,440	1148%
13	Бусад орлого	175,864	112,950	108,479	96%

Хувьцаа болон бонд, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны шимтгэл: 2023 онд биржид бүртгэлтэй компаниудын зах зээлийн үнэлгээ 11.6 их наяд төгрөгт хүрч, биржийн өдрийн дундаж арилжааны хэмжээ 3.0 тэрбум төгрөг болж, нийт арилжааны шимтгэлийн орлогоор 2.6 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлээ. Энд хувьцааны арилжаагаар 2,464.6 сая, компанийн бондын арилжаагаар 91.1 сая, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаагаар 42.7 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэн 2023 оны жилийн батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад арилжааны шимтгэлийн орлого 63%-ийн гүйцэтгэлтэй байлаа. Тайлант хугацаанд 2023 онд компанийн бондын арилжаагаар 1.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөн ажилласан хэдий ч энэхүү орлогын гүйцэтгэл 7% байна. Компани 2023 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд заасан 2023-2025 оны Засгийн газрын өрийн хэмжээний өөрчлөлттэй уялдуулан 2023 онд 1.8 их наяд төгрөгийн Засгийн газрын үнэт цаас (бонд) бүртгэн, арилжсанаар 1.1 тэрбум төгрөгийн арилжааны шимтгэлийн орлого олохоор төлөвлөсөн бөгөөд Сангийн яам болон биржийн зүгээс хамтран ажиллах гэрээний төсөл хийгдэн, бирж нь арилжааны бэлэн байдлыг хангах, платформыг бэлтгэх үйл ажиллагааг хийсэн боловч тус үнэт цаасыг олон нийтэд арилжаалах шийдвэр Сангийн яамнаас эцэслэгдэн гараагүй тул энэхүү орлого тасарсан болно. Тус үзүүлэлт нь арилжааны шимтгэлийн орлого буурсан голлох үзүүлэлт болж байна.

Бүртгэлтэй компанийн жилийн хураамж, хувьцаат компанийн элсэлтийн хураамж: Биржид нийт 173 хувьцаат компани бүртгэлтэй байдаг бөгөөд 2023 онд 2 компани, банкны системийн нөлөө бүхий 3 арилжааны банк шинээр хувьцаа гарган бүртгүүлээ. Компани 2023 оны гүйцэтгэлээр бүртгэлтэй компанийн жилийн үйлчилгээний хөлс, хураамжийн орлогоор 391.4 сая төгрөгийг төвлөрүүлсэнээр жилийн батлагдсан төлөвлөгөө 90%-ийн гүйцэтгэлтэй байна.

**Гишүүнчлэлийн жилийн хураамж, терминалын хураамж:** Биржийн гишүүн 51 үнэт цаасны компанийн гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нийт 109.3 сая төгрөгийн гишүүнчлэлийн жилийн хураамж, 63.4 сая төгрөгийн терминалын хураамжийн орлогыг тус тус төвлөрүүлсэн нь жилийн батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад гишүүнчлэлийн хураамжийн орлогын хувьд 143%, терминалын хураамжийн орлого 88% гүйцэтгэлтэйгээр орлогыг төвлөрүүллээ.

**Сургалтын төвийн орлого:** Үнэт цаасны зах зээлийн анхан шатны сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн сайжруулсны үндсэн дээр 10 сараас олон нийтэд зориулсан тус сургалтыг эхлүүлж, тайлант онд 3 удаагийн сургалтаар 8.2 сая төгрөгийн сургалтын орлого хүлээн авч ажиллаа.

**Мэдээллийн орлого:** Монголын хөрөнгийн биржийн арилжааны талаарх мэдээллийг гадаадын Bloomberg, Reuters, Exchange data International санхүүгийн мэдээллийн төв, дотоодын 20 компанитай байгуулсан гэрээний дагуу олон нийтэд түгээж, нийт 163.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь жилийн батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 81%-ийн гүйцэтгэлтэй байлаа.

**Бүртгэх үйлчилгээний хөлс болон бусад орлого:** Хөрөнгийн зах дээл дээр шинээр IPO гаргаж байгаа, шинээр нэмж үнэт цаас гаргаж байгаа болон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж байгаа компаниудын бүртгэх үйлчилгээний орлогоор 1.9 тэрбум, энэхүү бүртгэлийн өргөдөл хүлээн авч хянах үйлчилгээний орлогоор 40.0 сая төгрөг, уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны захиалга бүртгэх үйлчилгээгээний орлогоор 259.3 сая төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллаа. Маркетингийн багц үйлчилгээний орлогоор 28.0 сая төгрөг, ханшийн мэдээ болон архивын лавлагааны төлбөр, арилжаанд нэвтрэх ажилтны эрхийн төлбөр, оффисийн байр ашиглуулсны төлбөр, цахим тендерийн хураамж зэрэг бусад үйл ажиллагаанаас 68.0 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэнээр жилийн батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад бүртгэх үйлчилгээний орлого 104%, бусад орлого 96%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

**MIT системийн ашиглалтын орлого:** Арилжааны MIT системийн орчинд туршилт хийх үйлчилгээгээр 2022 онд шинээр үнэт цаасны 5 компанитай гэрээр байгуулан ажиллаж үйлчилгээний орлогоор 6.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

### **Үйл ажиллагааны зардлын талаар:**

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа шинээр эхлүүлж байгаатай холбогдуулан компанийн 2023 оны орлого, зардлын төлөвлөгөөг 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, үйл ажиллагааны зардлыг тодотгон 6,698.0 сая төгрөг байхаар баталсан бөгөөд тайлант онд компани 6,198.4 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй байгаа нь батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 93%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

(Хүснэгт 3)

## ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

/мян.төг/

#	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 он		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
<b>Б</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>3,629,394</b>	<b>6,697,999</b>	<b>6,198,409</b>	<b>92.5%</b>
1	Ажилтнуудын цалин хөлс	999,499	2,245,935	2,058,917	92%
2	НДШ-ийн зардал	126,870	296,451	256,963	87%
3	Удирдлагын зардал	93,035	151,387	152,809	101%
4	Материал, бичиг хэрэг	20,095	31,248	31,779	102%
5	Харилцаа холбооны зардал	6,096	8,624	7,709	89%
6	Интернет ашиглалт	18,617	22,424	15,484	69%
7	Шатахуун, тээврийн хэрэгслийн зардал	8,802	10,000	1,213	12%
8	Цахилгаан үүсгүүр цэнэглэлт		896	492	55%
9	Урсгал засвар	19,995	56,088	23,510	42%
10	Цахилгаан, дулаан, ус, хог	43,825	59,589	54,907	92%
11	Албан томилолт		83,969	35,086	42%
12	Сургалт семинар	6,061	69,372	28,525	41%
13	Ажилтнуудын нийгмийн зардал	18,774	36,000	4,465	12%
14	ЗЗ идэвхжүүлэлт, бизнес харилцааны зардал	62,880	66,375	47,300	71%
15	ХЭХ зохион байгуулалтын зардал		43,358	37,760	87%
16	Мэдээлэл технологийн зардал	27,615	149,370	111,367	75%
17	Бусад зардал	56,357	232,580	74,675	32%
18	Элэгдлийн зардал	396,509	928,994	609,066	66%
19	Зохицуулах үйлчилгээний хөлс /СЗХ/	117,121	195,861	704,567	360%
20	Арилжааны систем ашиглалтын зардал:	1,221,204	1,771,479	1,726,233	97%
	Үүнд: Арилжааны систем - Элэгдлийн зардал	342,168	684,336	684,336	100%
	Систем ашиглалтын зардал	879,036	1,087,143	1,041,897	96%
21	IPO зөвлөх үйлчилгээний зардал	386,039	238,000	238,000	100%

Удирдлагын зардал: Компанийн удирдлагын зардал нь ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, ТУЗ-ийн бичиг хэрэг бусад зардлаас бүрддэг бөгөөд 2023 онд ТУЗ-ийн гишүүдийн урамшуулалд 135.5 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 16.6 сая төгрөг, бичиг хэрэг бусад зардалд нийт 0.7 сая төгрөг нийт 152.8 сая төгрөг зарцуулж жилийн батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 101% хувийн гүйцэтгэлтэй байна.

Цалин хөлс, НДШ-ийн зардал: Компанийн 2023 онд батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу үндсэн ажилтны тоо 72 бөгөөд тайлант хугацаанд цалингийн зардалд 2,058.9 сая төгрөгийг, НДШ-ийн зардалд 257.0 сая төгрөгийг тус тус зарцуулж, жилийн батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад цалин хөлсний зардал 92% гүйцэтгэлтэй, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 87%-ийн гүйцэтгэлтэй цалин хөлсийн зардал 8%-ийн хэмнэлттэй гарсан байна.

Цахилгаан, дулаан, ус, хог: Компанийн ашиглалтын зардал 2023 оны гүйцэтгэлээр 54.9 сая төгрөг буюу 92% хувийн гүйцэтгэлтэй байлаа. Үүнд: Цахилгааны зардалд 40.7 сая, дулааны зардалд 9.5 сая, ус ашиглалт болон хог хаягдлын зардалд 5.1 сая төгрөгийг тус тус төлсөн байна.

**Материал, бичиг хэргийн зардал:** Компанийн материал, бичиг хэргийн зардал нь оффисийн хангамжийн материал, бичиг хэргийн материал, цэвэрлэгээний материал болон бага үнэтэй сэлбэг хэрэгслийн материалуудаас бүрддэг бөгөөд тайлант жилийн гүйцэтгэлээр тус зардал нь 31.8 сая төгрөг буюу жилийн батлагдсан төлөвлөгөө 102% гүйцэтгэлтэй байна. Материал, бичиг хэргийн материалын зардлын хэтрэлт нь тухайн жилийн барааны үнийн өсөлттэй шууд хамааралтай байгаа бөгөөд 2022 оны жилийн эцэстэй харьцуулахад 2023 онд өргөн хэрэглээний барааны үнэ 7.9%-ийн өсөлттэй байлаа. Компанийн албан хэрэгцээнд ашигласан бараа, материал төлөвлөсөн тоо хэмжээнээс нэмэгдээгүй болно.

**Харилцаа холбооны зардал:** Харилцаа холбооны зардал нь суурин утасны ярианы төлбөр, мобинет (ОУ-яриа), мобиком, шуудан хүргэлт, хэвлэл захиалга, тусгай дугаарын сунгалтын төлбөрүүдээс бүрддэг бөгөөд 2023 оны гүйцэтгэлээр 7.7 сая төгрөг буюу 89% гүйцэтгэлтэй 11%-ийн хэмнэлттэй ажиллаа. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангаж тайлант жилд хэвлэл захиалга хийгдээгүй болно.

**Урсгал засварын зардал:** Тайлант хугацаанд оффисийн 1 ба 3 давхаруудад байрлах ус цэвэршүүлэгчийн шүүр болон уян хоолойг солих, албан тасалгааны өрөөний хаалганы бариул, шалны ам дарагч зэргийг солих, компанийн өвлийн бэлтгэл ажилтай холбоотой дулааны шугам хоолойн ялтсан бойлерийг угаалгах, илүүдлийн хаалт солиулах, мэдээлэл технологийн алба болон санхүүгийн албаны өрөөнүүдийн жижиг засвар болон арилжааны заалны мэдээллийн дэлгэц засвар, цахилгаан генераторын тос масло солих үйлчилгээний ажилд нийт 20.0 сая төгрөгийг зарцуулж жилийн төлөвлөсөн зардал 40% хувийн гүйцэтгэлтэй байна.

**Сургалтын зардал:** Тайлант хугацаанд ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх сургалтад давхардсан тоогоор 14 ажилтан, худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад 2 ажилтан, компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтад 3 ажилтан, Монголын арилжаа эрхлэгчдийн холбооны аттестатчилах сургалтад 6 ажилтан, нийт ажилтнуудыг Баримт бичгийн стандарт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, KPI хийх аргачлал, гүйцэтгэл үнэлгээний сургалт хэлэлцүүлэгт тус тус хамруулан сургалтын зардалд нийт 25.1 сая төгрөг, үнэт цаасны анхан шатны сургалтын бичиг хэрэг, хангамжийн материалд 1.4 сая төгрөг, сургалтын багшийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 2.0 сая төгрөг нийт 28.5 сая төгрөгийг зарцуулсан нь батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 41%-ийн гүйцэтгэлтэй байна.

**Ажилтнуудын нийгмийн зардал:** 2023 онд нийгмийн зардалд ажилтнуудын спорт заал ашиглах түрээсийн төлбөр 4.3 сая төгрөг, буцалтгүй тэтгэмж 0.2 сая төгрөг нийт 4.7 сая төгрөгийг зарцуулсан болно.

**Интернэтийн зардал:** Байгууллагын үндсэн интернэт юнивишн, нөөц интернэт ситинет, дата төвийн шилэн кабель, мэйжикнэт төлбөрүүдээс интернетийн зардал бүрддэг бөгөөд үүнд 15.5 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төлөвлөгөө 69%-ийн гүйцэтгэлтэй байна.

**Зах зээл идэвхижүүлэлт, маркетингийн зардал:** Тайлант жилд маркетингийн зардлаар үнэт цаасны зах зээлийн мэдээ мэдээлийг сошиал сувгуудад boost хийх, үнэт цаасны зах зээлийн өдөрлөг зохион байгуулах, үнэт цаасны зах зээлийг идэвхижүүлэх

зорилгоор зах зээлийн зохицуулагч байгууллага Санхүүгийн зохицуулах хороо болон бусад байгууллагуудтай хамтран орон нутгийн бүсчилсэн уулзалт, хэлэлцүүлэгт оролцох, компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд зарлал, зар сурталчилгаа байршуулах зэрэг ажлуудад батлагдсан төлөвлөгөөний хүрээнд нийт 47.3 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд жилийн батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 71%-ийн гүйцэтгэлтэй байна.

Хувьцаа эзэмшигчдын хурлын зардал: Компани олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсоноор 2023 онд Хувьцаа эзэмшигчдын ээлжит болон ээлжит бус 2 удаагийн хурлыг онлайн болон танхим хосолсон байдлаар зохион байгуулсан бөгөөд эдгээр хурлын программын төлбөрт 9.1 сая төгрөг, онлайн платформ (zoom webinar)-ын төлбөрт 3.6 сая төгрөг, хурлын танхимын түрээсийн төлбөрт 12.5 сая төгрөг, хурлын шууд дамжуулалт, фото зургийн үйлчилгээнд 3.5 сая төгрөг, хурлын танилцуулгын видео бэлтгэхэд 3.2 сая төгрөг, тайлан хэвлэлд 2.5 сая төгрөг, хурлын зар нийтлүүлэх болон бичиг хэрэг, тараах материалын хэвлэл, хангамжийн материал зэргийн зардалд 3.3 сая төгрөг тус тус зарцуулж, нийт 37.7 сая төгрөгийн зардлыг зарцуулж батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 87%-ийн гүйцэтгэлтэй байлаа.

Мэдээлэл технологийн зардал: 2023 онд мэдээлэл технологийн зардлаар Айтүүлс болон Датаком компаниудад (cloud) сервер түрээсийн төлбөрт 3.9 сая төгрөг, оффис и-мэйлийн төлбөрт 3.4 сая төгрөг, шилэн кабел татуулах холбооны барилга угсралтын ажил гүйцэтгүүлэхэд 7.7 сая төгрөг, мэдээллийн аюулгүй байдлын стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний зардалд 9.8 сая, уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжааны Comex системд black-box аргачлалын дагуу нэвтрэлт шалгалт хийлгэхэд 3.0 сая төгрөг, үнэт цаасны арилжааны системүүдийн шинэчлэл, шинээр худалдан авсан серверүүдийн суурилуулалт, туршилт, нэвтрүүлэлтийн ажлыг хэрэгжүүлэх зорилгоор МИТ компанийн 3 мэргэжилтэн биржид ирж ажилласны зардалд 28.7 сая төгрөг, дотоодын мэдээлэл технологийн гэрээт ажлын төлбөрт 11.0 сая төгрөг, microsoft office 365 ашиглалтын 11, 12 дугаар сарын зардалд 3.2 сая төгрөг, вирус хамгаалалтын зардалд 5.3 сая төгрөг, IBM серверийн хард диск болон хөрвүүлэгчийг худалдан авахад 5.4 сая төгрөг, ажилтнуудын цаг бүртгэлийн апп-ийн зардалд 0.8 сая төгрөг, мэдээллийн аюулгүй байдлын стандартын дотоод аудитын зөвлөх үйлчилгээний зардалд 4.0 сая төгрөг, Comex системд хандах хүсэлтийн тоо нэмэгдүүлэх төлбөрт 1.0 сая төгрөг, шилэн кабелийн худаг, сувагчлалын түрээс, холболт үүсгэх техникийн нөхцөл, болон бусад зардалд 1.8 сая төгрөгийг тус тус, нийт 88.9 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөө 60%-ийн гүйцэтгэлтэй байлаа.

Бусад зардлын хүрээнд: Тайлант хугацаанд бусад зардлын ангиллаар 74.7 сая төгрөгийн зардал зарцуулсаны 1.8 сая төгрөгийг газрын болон АТӨЯХАТ-т, банкны шимтгэл хураамжид 6.1 сая төгрөг, аудитын үйлчилгээний төлбөрт 6.0 сая төгрөг, бусад мэргэжлийн ажил үйлчилгээний төлбөрт 15.6 сая төгрөг, нийгэм соёл болон бизнес харилцааны зардалд 13.2 сая төгрөгийг тус тус зарцуулсанаар батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэл 32% байна.

Нийгэм соёл, бизнес харилцаагаар: 2023 онд нийгэм соёлын зардалд 6.2 сая төгрөг зарцуулсанаас ОУ-ийн хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан цан цохих арга хэмжээнд 1.9 сая төгрөг, Хөрөнгийн зах зээлд оролцогч байгууллагуудын спорт арга хэмжээний зардалд 2.4 сая төгрөг, компани үүсгэн байгуулагдсан болон сар шинийн

баярын хүндэтгэлийн арга хэмжээ, “Тэрбум мод” аяны хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулах зэрэг ажлуудад нийт 2.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бизнес харилцааны зардлаар “Welcome to Mongolia” эдийн засгийн чуулга уулзалт-2023 форумд оролцогч гадаадын хөрөнгө оруулагч, төлөөлөгчид болон CNN телевизийн зочид төлөөлөгч, уул уурхайн бүтээгдэхүүний худалдагч компани болох Оюу-Толгой, Эрдэнэс таван толгой зэрэг дотоодын компаниуд, худалдан авагч харилцагч компаниудын болон зах зээлийн зохицуулагч байгууллагын холбогдох удирдлага төлөөллүүдтэй бизнес уулзалт зохион байгуулах зэрэг ажлуудад нийт 6.9 сая зарцуулсан байна.

Элэгдлийн зардал: Тайлант хугацаанд байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд 609.6 сая төгрөгийн зардлыг хуримтлуулан бүртгэсэн бөгөөд жилийн батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэл 66% хувьтай байна.

#### MIT цогц системийн ашиглалтын зардал

Тайлант хугацаанд MIT системийн элэгдэл, ашиглалтын зардалд нийт 1,726.2 сая төгрөг зарцуулснаас элэгдлийн зардалд 684.3 сая төгрөг, зогсуур түрээс болон ашиглалтын зардалд 1,041.9 сая төгрөгийг гарсан. MIT системийн 2023 оны 4-р улирлын үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх гэрээний төлбөр болох 65500 ам.долларыг зардалд хүлээн зөвшөөрч, өглөгт хуримтлуулан бүртгэсэн болно. Эдгээр нь жилийн батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 97% хувийн гүйцэтгэлтэй байна.

#### Авлагын талаар:

Тайлант хугацаанд өмнөх онуудын хураамжийн үлдэгдэлтэй 18 бүртгэлтэй ХК-иас 27.8 сая төгрөгийн авлага, ҮЦК-ийн 1.2 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан. Нийт авлагын дүнд өндөр хувийг буюу 450.0 сая төгрөгийн үнэт цаас бүртгэх үйлчилгээний төлбөртэй Мандал ирээдүйн өсөлт ХОС-ийн авлагыг өнгөрсөн хугацааны алдангийн хамт төлүүлэхээр иргэний шүүхэд хандан нэхэмжлэл гарган ажиллаж байна. Үүний сацуу 13 компанийн эзэн холбогдогчийг цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 3 компани, компанийн албан ёсны хаяг тодруулахаар албан хүсэлт хүргүүлсэн 1 компани байгаа бол 2024 оны 1 улиралд 3 компани төлбөр барагдуулахаа илэрхийлсэн байна.

#### Өглөгийн талаар:

Тайлант хугацаанд MIT цогц системийн программ хангамжийн лицензийн 2022 оны 3-12 саруудын ашиглалтын төлбөрийн 769.4 сая төгрөгийн өглөгийг бүрэн төлж барагдуулан, ОСБНӨАТ-ийн өглөгт бүртгэлтэй байсан 75,2 сая төгрөгийг МУ-ын Улсын төсөвт шилжүүлсэн.

#### Уул уурхайн биржийн арилжааны дэнчингийн төлбөр тооцоогоор:

Валют	Орлого	Зарлага		Үлдэгдэл
		Худалдагчид	Харилцагчид	
Ам.доллар	369,421,883.17	5,687,255.00	129,844,944.31	233,889,683.86
Гүйлгээний тоо	262	14	102	Нийт-378
Юань	312,595,875.75	45,359,874.62	93,827,865.18	173,408,135.95
Гүйлгээний тоо	194	37	51	Нийт-282

**Хөрөнгө оруулалт, худалдан авалтын талаар:**

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2023 онд 82 төсөл, арга хэмжээг нийт 2,011.1 сая төгрөгийн үйл ажиллагаа болон олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн ба үүнээс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 60 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг нийт 1,162.7 сая төгрөгөөр санхүүжүүлэн, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу шалгаруулалтыг хийж, холбогдох гэрээг байгуулан дүгнэж, худалдан авах ажиллагааг зохион байгууллаа.

Тайлант жилийн хугацаанд “Дагалдах өгөгдлийн сангийн лицензүүд /Oracle Database Enterprise Edition 2 core, CPU based+6ш багц лиценз/”-ийн 1 худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтаар, “Ширээ”, “Гадна талбайн хяналтын камер”, “Oracle Linux premier support сунгалт”, “Сервер-2ш /Арилжааны дэд системүүдэд/”, “Сервер-2ш /Үндэсний дата төвд байрших/”, “Windows license /10,11/”, “VMWare vSphere серверийн лиценз” зэрэг 7 төрлийн тавилга, тоног төхөөрөмж, лицензийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар, “Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох ажлын хүрээнд /Барилгын дотоод зохион байгуулалтын шинэчлэлтийн зураг төсөв/” боловсруулах 1 зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг тус тус ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу Гүйцэтгэх захирлын тушаалаар үнэлгээний хороод байгуулан, сонгон шалгаруулалтыг хийсэн байна.

2023 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний 1,198.9 сая төгрөгийн хэрэгжилтийг төсөвт өртгөөр салган авч үзвэл:

№	Худалдан авалт	ХАА-д мөрдөх журам, арга	/Мянган төгрөгөөр/	
			Санхүүжсэн дүн	Хувиар
1	Нээлттэй тендер шалгаруулалт	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	192,119.80	16%
2	Харьцуулалтын арга	Тендер шалгаруулалтын онцгой журам, ХА	322,235.62	27%
3	Зөвлөх үйлчилгээ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам	67,136.85	6%
4	Шууд худалдан авалт	Шууд худалдан авах	398,328.01	33%
5	ХАА-ны аргыг өөрчлөн худалдан авсан худалдан авалт	Нээлттэй тендер шалгаруулалт à Харьцуулалтын арга, Шууд худалдан авалт	26,235.00	2%
6	Нэг эх үүсвэрээс худалдан авсан худалдан авалт	Нэг эх үүсвэр/гүйцэтгэгчтэй ажил	60,000.00	5%
7	Ерөнхий гэрээний дагуу худалдан авалт	Ерөнхий гэрээ байгуулах арга	132,859.05	11%
<b>Нийт хэрэгжилт</b>			<b>1,198,914.32</b>	<b>100%</b>

Нийт хэрэгжилтийн 16% буюу 192.1 сая төгрөгийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар худалдан авсан бараа, 27% буюу 322.2 сая төгрөгийг тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар худалдан авсан бараа, 6% буюу 67.1 сая төгрөгийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журмаар худалдан авсан үйлчилгээ, 33% буюу 398.3 сая төгрөгийг шууд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ, 2% буюу 132.9 сая төгрөгийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн Цахим дэлгүүрээс ерөнхий гэрээ байгуулах аргаар худалдан авсан бараа тус тус эзэлж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн тогтоолын хавсралтаар батлагдсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын дагуу экспортод гаргах нүүрсийг биржээр дамжуулан арилжаалах болсонтой холбоотой дуудлага арилжааны Comex системийг богино хугацаанд хөгжүүлж, 2023 оны 2 дугаар сараас нэвтрүүлэх шаардлага тулгарсан тул туршлагатай мэргэжилтэнтэй гэрээ байгуулан хамтран ажиллах нь хамгийн үр дүнтэй, боломжит хувилбар байсан бөгөөд Систем нэвтрүүлснээс хойш хэрэглэгчийн шаардлагын дагуу нэмэлт сайжруулалт хийх, хэвийн ажиллагааг нь хангахын тулд тухайн системийг хөгжүүлсэн зохиогч болон туршлагатай мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Хоёрдогч арилжааны системийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн ажлын хүрээнд дэд бүтэц шинээр зохион байгуулагдаж, түүний дагуу ашиглах лицензийн өөрчлөлт, худалдан авах тоног төхөөрөмжийн үзүүлэлт шаардлагууд систем нийлүүлэгч талаас эцэслэн ирүүлсний дараа худалдан авалтыг зохион байгуулсан нь худалдан авалтын хугацаанд нөлөөлсөнтэй холбоотой МХБ/202311117 тендерийн дугаартай “Сүлжээний галт хана /Firewall/” барааг нээлттэй тендерээр худалдан авах тендерийн урилгыг 2023 оны 12 дугаар сард нийтэлж, 2024 оны 01 дүгээр сард тендерийн нээлтийг зохион байгуулахаар он дамжин хэрэгжиж байна.

### Хөрөнгө оруулалтын талаар

/мянган төгрөг/

	Бараа, ажил, үйлчилгээ	Тоо хэмжээ	Төлөвлөгөө	Тоо хэмжээ	Гүйцэтгэл	%
1	Тавилга эд хогшил	105	74,035.80	92	56,272.56	76%
2	Тоног төхөөрөмж	135	519,376.90	122	392,229.95	76%
3	Биет бус хөрөнгө	64	33,969.36	0	0	
4	Барилга байгууламжийн засвар үйлчилгээ	1	165,000.00	0	0	
<b>Бүгд дүн</b>		<b>305</b>	<b>792,382.06</b>	<b>214</b>	<b>448,502.51</b>	<b>57%</b>

### Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт талаар

/мянган төгрөг/

№	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	Гүйцэтгэл 2023 он			
1	Арилжааны систем сайжруулалт	7,590,339.31	63.70%	1,264,996.97	10.6%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	1,274,986.35	10.70%	65,896.31	0.6%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	726,861.38	6.10%	76,801.45	0.6%
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	2,323,573.26	19.50%	79,417.25	0.7%
<b>Нийт</b>		<b>11,915,760.30</b>	<b>100%</b>	<b>1,487,111.98</b>	<b>12%</b>



Арилжааны систем сайжруулалтын ажлын хүрээнд:

- Үнэт цаасны арилжааны системийн жилийн үйлчилгээний зардалд: 906.8 сая
- IPO системийн шинэчлэл: 10.0 сая
- Уул уурхайн спот, форвард арилжааны систем (Comex ): 50.0 сая
- Арилжааны системийн үйлдлийн системийн лицензүүд: 160.7 сая
- Арилжааны системийн сервер тохируулга, лицензийн шинэчлэл: 137.5 сая (50%)

Мэдээлэл технологийн аюулгүй байдлын ажлын хүрээнд:

- Серверийн өрөөний стандартжуулалтын зураг төсөв үнэ: 19.9 сая
- Серверийн өрөөний хөргөлтийн төхөөрөмж үнэ: 18.4 сая
- VMWare серверийн лиценз: 27.6 сая

Дотоод үйл ажиллагааны цахимжуулалтын ажлын хүрээнд:

- Microsoft office 365 хэрэглээний программ хангамжийн лиценз: 15.7 сая
- Windows үйлдлийн системийн хугацаагүй лиценз: 34.9 сая
- Санхүү, татварын программ хангамж (2ш): 26.2 сая

Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох ажлын хүрээнд:

- 4.1. Мэдээлэл үйлчилгээний төв бий болгох ажлын зураг төсөв: 67.1 сая
- 4.2. Барилгын экспертизийн дүгнэлт: 12.3 сая

төгрөгийн зардал, хөрөнгө оруулалтын ажлуудыг тус тус хийж гүйцэтгэн нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 12%-ийн зарцуулалтыг 2023 онд хийлээ.

---ooOoo---

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1



### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Г Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайланг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Хараат бус аудиторын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан баталж, хэрэгжилтийг улирал тутам тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.

3. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг компанийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010047

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2



### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

#### Төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйл, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.7.27 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 06 дугаар дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг Нэгдүгээр хавсралтаар дэмжсүгэй.
2. Компанийн 2024 оны Бизнес төлөвлөгөөг Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Компанийн 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний санал, 2024 оны Бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчид болон зохих байгууллагад хүргүүлэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

152201045

**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН 2024 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН  
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ САНАЛ**

№	Үзүүлэлтүүд	2022 оны гүйцэтгэл*	2023 он		2024 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэлтэй харьцуулсан өөрчлөлт	
			Тодотгосон төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл*		%	мөнгөн дүн
<b>1</b>	<b>Нийт орлого:</b>	<b>4,268,416</b>	<b>9,783,712</b>	<b>13,777,494</b>	<b>17,778,554</b>	29%	4,001,060
1.1	Үнэт цаасны арилжааны шимтгэл	2,031,112	4,112,424	2,583,028	3,147,318	22%	564,290
1.2	УУББ-ийн арилжааны шимтгэл		2,552,931	4,821,917	6,521,185	35%	1,699,268
1.3	Жилийн хураамж, үйлчилгээний хөлс	1,869,696	2,365,350	2,317,088	1,485,794	-36%	-831,294
	МІТ ашиглалтын орлого	6,364					
1.4	Хүүгийн орлого		397,500	3,782,215	6,250,000	65%	2,467,785
1.5	Бусад	361,244	355,507	273,246	374,257	37%	101,011
<b>2</b>	<b>Нийт зардал:</b>	<b>3,629,535</b>	<b>6,698,000</b>	<b>7,395,090</b>	<b>9,428,972</b>	<b>28%</b>	<b>2,033,882</b>
2.1	Үйл ажиллагааны зардал	2,011,822	3,997,527	5,022,743	6,226,234	<b>24%</b>	1,203,491
2.2	Удирдлагын зардал				449,188	-	
2.3	УХ элэгдлийн зардал	396,509	928,994	600,868	900,532	50%	299,664
2.4	Арилжааны систем ашиглалтын зардал	1,221,204	1,771,479	1,771,479	1,853,017	5%	81,538
<b>3</b>	<b>Татварын өмнөх цэвэр орлого /алдагдал/</b>	<b>769,748</b>	<b>3,085,712</b>	<b>6,382,404</b>	<b>8,349,582</b>	<b>31%</b>	<b>1,967,178</b>
4	Орлогын татвар	123,520	391,086	316,104	834,958	164%	518,854
<b>5</b>	<b>Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>646,228</b>	<b>2,694,626</b>	<b>6,066,300</b>	<b>7,514,624</b>	<b>23.9%</b>	<b>1,448,323.8</b>
6	Нийт авлага /цэвэр/	504,659	51,460	674,334	250,092		(424,242)
7	Нийт өглөг /системийн зардал оруулж тооцсоноор/	1,989,504	218,319	1,031,617	848,455		(183,162)
	УУББ-ийн арилжааны дэнчингийн мөнгө			881,747,146	881,747,146		-
8	Ажиллагсдын тоо	53	72	72	72		-
9	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	0.85	0.68	0.54	0.53		(0.01)
10	Хөрөнгө оруулалт	557,807	5,899,400	1,093,971	1,110,664	1.5%	16,693

/мянган төгрөг/

# ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”  
ХК-Д

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2023.08.29 № 5 / 3360  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т


### Хариу хүргүүлэх тухай

Танай 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/556 тоот албан бичгээр ирүүлсэн оноосон нэрийн өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлт хүргүүлэх тухай хүсэлтэй танилцлаа.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж” гэсэн тэмдэглэгээг зөвхөн энэ хуулийн дагуу байгуулагдсан бирж оноосон нэрэндээ хэрэглэх бөгөөд бусад этгээдийн оноосон нэрэнд хэрэглэхийг хориглоно” буюу “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж” гэсэн тэмдэглэгээг ашиглахаар зохицуулсан. Гэвч “Монголын хөрөнгийн бирж” ХК нь оноосон нэрийн ард “УУББ” гэсэн тэмдэглэгээг ашиглахаар шийдвэрлэсэн нь тус хуулийн заалтад заасан “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж” гэсэн тэмдэглэгээг товчилсон тэмдэглэгээ байгаа нь тус хуулийн заалттай нийцэхгүй байна.

Иймд дээрх хуулийн шаардлагад нийцсэн тэмдэглэгээг ашиглах шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж байна.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭЖ  
Б.ДӨЛГӨӨН



1518006157



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Цагдаагийн гудамж, 11 дүгээр хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14171  
Утас: 32 05 02, Цахим шуудан: contact@burtgel.gov.mn,  
Цахим хуудас: www.burtgel.gov.mn

№ 2023.10.13 № 4/9585  
танай 2023.09.17-ны № 01/531 -т

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Х.АЛТАЙ ТАНАА**

Танаас ирүүлсэн 01/531 дугаар албан бичигтэй танилцлаа.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж” гэсэн тэмдэглэгээг хуулийн дагуу байгуулагдсан бирж оноосон нэрэндээ хэрэглэхээр заасан байх тул “Монголын хөрөнгийн бирж УУББ” гэх нэрийг баталгаажуулах шаардлагагүй байна.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА **Ж.АЮУШ**



142308914



## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 30 өдөр

№ 8

Улаанбаатар хот

### Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн албан ёсны оноосон нэрийг “Монголын хөрөнгийн бирж УУББ” ХК гэж өөрчилсүгэй.
2. “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан дүрэмд дор дурдсан агуулга бүхий бүлэг, зүйл, заалтыг нэмсүгэй. Үүнд:

1/. Наймдугаар бүлэг:

“Наймдугаар бүлэг. Маргаан таслах зөвлөл

8.1. Бирж нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцогч хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий маргаан таслах зөвлөл /цаашид "маргаан таслах зөвлөл" гэх/-тэй байх бөгөөд маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

8.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцогч нь биржийн арилжаатай холбоотой гомдлоо арилжаа хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор маргаан таслах зөвлөлд гаргана.

8.3. Маргаан таслах зөвлөл гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 8.3.1. гомдлын шаардлагыг хангах;
- 8.3.2. гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгох;
- 8.3.3. гомдлын хүрээнд арилжааны шийдвэрт өөрчлөлт оруулах.

8.4. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцогч нь маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.”

2/4.8.14 дэх заалт:

“4.8.14. компанийн зорилтот түвшинг батлах;”

3/ 5.7.20 дахь заалт:

5.7.20. Брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнээс хасах;

4/5.7.26 дахь заалт:

5.7.26. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан холбогдох журмыг баталж мөрдүүлэх;"

5/ 6.11.14 дэх заалт:

"6.11.14. Компанийн сайн засаглалын зарчмыг мөрдөж ажиллах;"

3. Мөн Дүрмийн 1.1 дэх заалтын "бирж" гэсний дараа "УУББ" гэж, 2.3 дахь заалтын "хувьд" гэсний дараа "мөн Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг гүйцэтгэгчийн хувьд" гэж, мөн заалтын "эрхлэх" гэсний дараа "тооцооны" гэж, 5.2 дахь заалтын "хууль" гэсний дараа "болон холбогдох бусад хууль тогтоомжид" гэж, 6.3 дахь заалтын "захирал нь" гэсний дараа "холбогдох хууль, тогтоомж болон" гэж, мөн заалтын "шалгуурыг" гэсний дараа "тус тус" гэж, 6.15.4 дэх заалтын "судалж" гэсний дараа "ёс зүйн хэм хэмжээг сахин," гэж тус тус нэмсүгэй.
4. Мөн Дүрмийн 1.10 дахь заалт, 2.1 дэх заалт, 2.2 дахь заалт, 5.4 дэх заалт, 5.7.19 дэх заалт, 5.25.3, 5.25.5, 5.25.6 дэх заалт, 5.38.3 дахь заалт, 5.40.1 дэх заалт, 6.7 дахь заалт, 6.9.6 дахь заалт, 6.10.1, 6.10.2 дахь заалт, 6.11 дахь заалт, 6.14.1 дэх заалтыг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

1/ 1.10 дахь заалт:

"1.10. Компанийн оноосон нэрийг Монгол хэлээр "Монголын хөрөнгийн бирж УУББ" ХК, Англи хэлээр "Mongolian Stock Exchange (Mining Commodities Exchange)" JSC буюу "Mongolian Stock Exchange MCE" JSC , товчоор "MSE MCE" JSC гэнэ. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрийнхээ дараа "Уул уурхайн бүтээгдэхүүний бирж (УУББ)" болон "ХК" гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ."

2/ 2.1 дэх заалт:

"2.1. Компанийн эрхэм зорилго нь үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг сэргээн хөгжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, дэмжин урамшуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлэхэ, уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг нээлттэй ил тод зохион байгуулахад оршино."

3/ 2.2 дахь заалт:

"2.2. Компанийн үйл ажиллагаа нь үнэт цаасны зах зээлд үнэт цаасны болон уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа эрхлэх, тооцооны болон өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа, хуулиар зөвшөөрсөн бусад арилжаа, эрхлэхэд чиглэсэн байна."

4/ 5.3, 5.4 дахь заалт:

"5.3. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 4 нь хараат бус гишүүн байна."

"5.4. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно."

5/ 5.7.19 дэх заалт:



“5.7.19 дэх заалтыг Компанийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах”

6/ 5.25.3, 5.25.5, 5.25.6 дахь заалт:

“5.25.3. хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулага хийх;”

“5.25.5. компанийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хийсэн дотоод хяналтын албаны хяналт шалгалтын тайлантай нарийвчлан танилцах, шаардлагатай гэж үзвэл лавшруулан хянах, тухайн худалдан авах үйл ажиллагаа нь үр ашиггүй гэж үзвэл худалдан авалтыг зогсоох, цуцлах эрхийг эдлэнэ;”

“5.25.6. хуульд заасан бусад эрх, үүрэг.”

7/ 5.38.3 дахь заалт:

“5.38.3. компанийн эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, эрсдэлийн түвшинд хяналт тавих.”

8/ 5.40.1 дэх заалт:

“5.40.1. компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтан, ажилтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;”

9/ 6.7 дахь заалт:

“6.7. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.”

10/ 6.9.6 дахь заалт:

“6.9.6. ТУЗ-өөс баталсан зардал, бизнес төлөвлөгөөнд туссан бүтэц орон тооны хязгаарт багтаан нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;”

11/ 6.10.1, 6.10.2 дахь заалт:

“6.10.1. энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-өөс өгсөн үүрэг, чиглэл, шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, зохицуулагч байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулж ТУЗ-д тайлагнах;”

“6.10.2. компанийн стратегийн төлөвлөгөө болон эрсдэлийн удирдлага, зохистой засаглал, ёс зүйн хэм хэмжээний талаарх дотоод дүрэм, журам, заавар боловсруулж ТУЗ-д танилцуулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж хангах;”

12/ 6.11 дахь заалт:

“6.11. Гүйцэтгэх захирал нь үйл ажиллагааны стратеги, бизнес төлөвлөгөөнд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах талаар хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлээгүй, санаатай тасалдуулсан, энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан, тэдгээрийг ноцтой зөрчсөн тохиолдолд ТУЗ түүнийг

үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл болно. Гүйцэтгэх захирал нь ажлаас чөлөөлөгдөхдөө хүндэтгэн үзэхээс бусад тохиолдолд үүрэгт ажлаа өөрийн биеэр биечлэн хүлээлгэн өгнө.”

13/ 6.14.1 дэх заалт:

“6.14.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллахдаа Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-өөс өгсөн үүрэг чиглэлийг биелүүлэхэд гүйцэтгэх удирдлагад бүхий л байдлаар дэмжлэг үзүүлж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;”

5. Мөн Дүрмийн 5.7.21 дэх заалт, 6.5 дахь заалтыг тус тус хассугай.
6. Энэ тогтоолоор дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тусгасан “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийг хавсралтаар баталгаажуулсугай.
7. Компанийн оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор компанийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг холбогдох хууль, журмын дагуу эрх бүхий байгууллагад өөрчлөлтийг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
8. Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлтийг холбогдох журмын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн, нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
9. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  С. ТУЛГА

## ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

ТӨСӨЛ

### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.9 дэх заалт, 2024 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын .... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**Д.ТОГТОХБАЯР**

ТӨСӨЛ**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн  
2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.14 дэх заалт, 2024 оны 4 дүгээр сарын 26–ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын .... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Тогтохбаяр)-д тус тус даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА****Д.ТОГТОХБАЯР**

ТӨСӨЛ**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.15 дахь заалтууд, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ..... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар тогтоолд дараах өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:
  - 1) 1, 7 дахь хэсгүүд болон 4 дэх хэсгийн 1-т заасныг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
  - 2) 4 дэх хэсгийн "1.10 дахь заалт" гэснийг хассугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар тогтоолд өөрчлөлт оруулснаас бусад хэсгийг хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА****Д.ТОГТОХБАЯР**

## САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....

Регистрийн дугаар .....

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн тоо: .....

Бүртгэсэн / Үнэт цаасны компани / .....

Брокерийн овог: ..... нэр: .....

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 09:00 цагт болно.

**Дараах хэлэлцэх асуудлуудад ЕРДИЙН АРГААР санал хураана.**

**Саналын хуудас бөглөх заавар:** Ердийн журмаар саналаа өгөхөд асуудал бүрээр "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нь болохыг ✓ тэмдэглэж санал болгоны ард **гарын үсгээ зурна.**

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ	Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал	Гарын үсэг
1.	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах;	Ердийн	Тогтоол №1	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
2.	Компанийн 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах		Тогтоол №2	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
3.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.		Тогтоол №3	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		

Саналын хуудсыг бүртгэж, хүлээн авсан албан тушаалтны гарын үсэг, гарын үсгийн тайлал:  
..... /

2024 оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ өдөр

### САНАЛ АВАХ ХУУДСЫГ БӨГЛӨХ САНАМЖ

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.

1. Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаяг байрлах Монголын хөрөнгийн биржийн байр, цахим хэлбэрээр өгөх бол Монголын хөрөнгийн биржийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудсаар өгч болно.
2. Та урьдчилан санал өгсөн бол дахин тухайн асуудалд санал өгөх эрхгүй.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулах ба тухай саналын хуудсыг итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
4. Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:
  - 4.1. Та саналын хуудсыг бөглөхдөө тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл **+ тэмдгээр саналаа өгнө.**
  - 4.2. **Засварласан, балласан эсвэл аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.** Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаяг байрлах Монголын хөрөнгийн биржийн байр, цахим хэлбэрээр өгөх бол Монголын хөрөнгийн биржийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудсаар өгч болно.
  - 4.3. Та урьдчилан санал өгсөн бол дахин тухайн асуудалд санал өгөх эрхгүй.
  - 4.4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулах ба тухай саналын хуудсыг итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.

*Энэ хэсгийг Тооллогын комисс бөглөнө.*

Хэлэлцэх асуудал № ....., ....., ....., ..... саналыг **хүчинтэйд** тооцов.

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал:...../ /

Хэлэлцэх асуудал № ....., ....., ....., ..... саналыг **хүчингүйд** тооцсон шалтгаан:

.....  
.....  
.....

